# ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 07 өдөр    Дугаар А/146    Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралт, “Шударга байдлын үнэлгээ”-г дээшлүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг сар бүрийн 20-ны дотор тайлагнаж, хариуцсан арга хэмжээг тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлэхийг алба, хэлтэс, харьяа салбар, нэгжийн дарга нарт даалгасугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хууль, эрх зүйн хэлтэс (З.Туяа), төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг даргын зөвлөлд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба (Б.Мөнх-Очир)-нд тус тус даалгасугай.

ДАРГА    Ч.МӨНХТУЯА

.7120 0138

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2024 оны 03 дугаар сарын 07 –ны өдрийн
А/146 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хуга-цаа | Хариуцах нэгж | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, youtube суваг ) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр нийтэд хүргэнэ. | Тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудсыг ИНЕГ, түүний харьяа салбар нэгжүүдийн цахим хуудсанд байршуулж, баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх;<br><br>Түгээсэн тоо, давтамж, хандалтын тоо. | ИНЕГ, түүний харьяа салбар нэгжүүдийн цахим хуудсанд мэдээллийг байршуулж, баримтжуулан, үр дүнг ИНЕГ-т тайлагнасан байна. | Улирал бүр | ХШҮДАА ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХАХ<br><br>ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжүүд | Авлигатай тэмцэх газрын бэлтгэсэн шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг байгууллагын цахим хуудсанд байршуулж, бусад нийгмийн сүлжээгээр нийтэд хүргэж, баримтжуулан, мэдээллийг тайланд хавсаргаж, улирал бүр ХШҮДАА-нд ирүүлэх.<br>Түгээсэн тоо, давтамж, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хандалтын тоог тайланд тодорхой тусгахад анхаарах. |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулна. | 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br><br>Үр дүнг тооцож, нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:**<br>**1** арга хэмжээг ИНҮТ, түүний салбар, нэгжүүдийг хамруулан зохион байгуулж, тайлагнасан байна. | 4 сард | ИНҮТ-ийн ХНУГ ХХ | Арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулж, тайланг, нотлох баримтын хамт ИНЕГ-ын ХШҮДАА-нд ирүүлэх. |
| | | | | **Жилийн эцэст:**<br>1 арга хэмжээг ИНЕГ зохион байгуулж, тайлагнасан байна. | 10 сард | ХШҮДАА ЗУХЭЗХ | Арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулж, нотлох баримтыг бүрдүүлэх. |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулна. | Байршуулсан мэдээллийн тоо | **Эхний хагас жилд**: 5<br><br>**Жилийн эцэст**:6 | Сар бүр | ХШҮДАА | Мэдээллийн самбарын мэдээллийг сар бүр шинэчилсэн талаарх нотолгоог бүрдүүлэх. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж, олон нийтэд хүргэнэ. | -3-аас доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;<br><br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг ) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр нийтэд хүргэсэн байх;<br>-Сурталчилгааны материалдаа авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх | **Эхний хагас жилд**:<br>1 /зурагт хуудас/<br>1 /шторк/<br><br>**Жилийн эцэст**:1/шторк/ | 4,5,9 сард | ИНҮТ-ийн ХАХ | Сурталчилгааны материал боловсруулж, байгууллагын цахим хуудсанд болон олон нийтийн сүлжээнд байршуулсан талаарх мэдээллийг ХШҮДАА-нд тайлагнах / зурагт хуудас, шторкийг эх хувиар, мэдээллийг хэзээ, хаана байршуулсныг батлах зургийг хавсаргах/ |
| 2. | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, | 2.1.Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулна. | Сургалтад хамруулсан ажилтнуудын тоо | **Эхний хагас жилд:**<br>Гүйцэтгэлээр, 1<br><br>**Жилийн эцэст**: | I-IV улирал | ХШҮДАА ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХНУГ | Тайланд нотолгоог хавсаргах /сургалт зохион байгуулж буй зураг, сургалтад |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтад хамруулах | | Зохион байгуулсан сургалтын тоо | Гүйцэтгэлээр, 1 | | ХХ | хамрагдсан албан тушаалтнуудын бүртгэл/ |
| | | 2.2.НААХЗА-ны нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчдад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг зохицуулах талаарх сургалт хийнэ. | Сургалтад хамруулсан ажилтнуудын тоо Зохион байгуулсан сургалтын тоо | **Эхний хагас жилд:** 53; 1 | 4 сард | ХШҮДАА | |
| | | 2.3.Тус байгууллагаас үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | **Эхний хагас жилд:** 1 | II улирал | НААХЗА | Тусгай зөвшөөрөл олгож буй үйл ажиллагаа болон Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас олгож буй тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн талаарх мэдээллийг өгөх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг ХШҮДАА-нд ирүүлэх6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна. | - Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br><br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br><br>- Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тусгах;<br><br>- Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;<br><br>- Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байна.<br><br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байна.<br><br>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тусгана. | I-IV улирал | ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХНУГ<br>ХХ | Тайланг эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргахдаа хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэж, нотлох баримтыг хавсаргах<br>. |
| | | 3.2.Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам-ыг хэрэгжүүлэх | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; | **Эхний хагас жилд:**<br>Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байна. | 2-3 сард | ЗУХЭЗХ | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлж, жагсаалтыг ХШҮДАА-нд хүргүүлэх. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | | Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | ИНЕГ-ын олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд болон ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдалд олон нийтийн хяналтыг 2023 онд хэрэгжүүлсэн тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлсэн | 2-5 сард | ЗУХЭЗХ ХҮШДАА<br><br>ИНҮТ-ийн ХОЗА | ИНЕГ-ын олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд болон ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдалд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, тайланг ХШҮДАА-нд ирүүлэх. /Тайланг 2024.12.11-нд албан бичгээр хүргүүлсэн/ |
| | | | | **Жилийн эцэст:** Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх холбогдох этгээдийг шалгаруулах | 6-7 сард | ЗУХЭЗХ<br><br>ИНҮТ-ийн ХНУГ ХХ | Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх холбогдох этгээдийг шалгаруулах ажлыг зохион байгуулж, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулах арга хэмжээ авсан байна. | | ИНУТ, түүний харьяа салбар, нэгжүүд | гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байгууллагын тайланг хүлээн авах; |
| | | | | Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байна. | 8-11 сард | | Хяналтын чиг үүргийг гүйцэтгэсэн этгээдийн тайлан, дүгнэлтийг хүлээн авч, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, тайланг нэгтгэж, ХШҮДАА-нд ирүүлэх. |
| 4. | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.НААХЗА-наас олгож буй тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлнэ. | Тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн байх. | **Жилийн эцэст:** Тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | I улирал | НААХЗА<br>ИНУТ-ийн МТХ | - |
| | | 4.2.Тус газарт ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоно. | Дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байх. | **Эхний хагас жилд:** Дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг | 3 сард | ЗУХЭЗХ | Тус газарт 2023 онд ирүүлсэн гомдолд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, тайланг удирдлагад танилцуулж, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тодорхойлсон байна. | | | ХШҮДАА-нд тайланг нотлох баримтын хамт ирүүлэх |
| | | 4.3.Авлигатай тэмцэх газрын даргын 2019 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал"-ын дагуу байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээ хийж боловсруулсан Авлигын эсрэг баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангана. | Авлигын эсрэг баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжилт, хувиар. | **Эхний хагас жилд**: Төлөвлөгөөг батлуулсан байна. | 2 сард | ХШҮДАА | |
| | | | | **Эхний хагас жилд**: 50%<br><br>**Жилийн эцэст:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн байна. | II-IV улирал | ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ-ийн нэгжүүд | |
| | | 4.4.Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулна. | Бодитой үр дүнг тооцсон байх.<br><br>Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:** Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэж, санал, дүгнэлт гаргасан байна. | 5 сард | ЗУХЭЗХ | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэж, зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэх. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Жилийн эцэст:** Судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулсан байна. | III-IV улирал | НААХЗА<br><br>ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжүүд | Судалгааны дүгнэлтэд тулгуурлаж холбогдох арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тогтоосон хугацаанд ХШҮДАА-нд нотлох баримтын хамт ирүүлэх |
| | | 4.5.Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, өмнөх оны үнэлгээг дээшлүүлнэ. | Байгууллагын царим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулсан эсэх | **Эхний хагас жилд:** Мэдээллийг 100% байршуулсан байна.<br>**Жилийн эцэст:** Мэдээллийг 100% байршуулсан байна. | 1-11 сард | ЗУХЭЗХ ИНЕГ-ын нэгжүүд | |
| 5. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1.Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилтийг явцыг эхний хагас жилд, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулна. | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br><br>-Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br><br>-Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:** Төлөвлөгөөг танилцуулсан байна. | 3 сард | ХШҮДАА | Танилцуулах, үр дүнг тайлагнах арга хэмжээнүүдийг зохион байгуулж, тайлагнах.<br><br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцүүлсэн байх. |
| | | | | Хэрэгжилтийг явцыг танилцуулсан байна. | 6 сард | ХШҮДАА | |
| | | | | **Жилийн эцэст:** Хэрэгжилт хүрсэн үр дүнг нийт албан | 11 сард | ХШҮДАА | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хаагчдадаа танилцуулсан байна. | | | |
| | | 5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм, журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байна. | -Санал тусгасан байх;<br><br>-Тайланд нотлох баримтыг хавсаргасан байх. | **Эхний хагас жилд:** Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ, харьяа салбар, нэгжүүд | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг холбогдох дүрэм, журамд тусгаж, нотлох баримтыг тайланд хавсаргаж ирүүлэх. |
| | | 5.3.Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангана. | Төлөвлөгөөг боловсруулж, АТГ-аар хянуулж батлуулсан эсэх<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | **Эхний хагас жилд:** Төлөвлөгөөг батлуулсан байна.<br>80%-д хүргэсэн байна. | 2 -6 сард | ХШҮДАА<br><br>ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ, харьяа салбар, нэгжүүд | |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | **Жилийн эцэст:** 100%-д хүргэсэн байна. | 7-9 сард | ИНЕГ-ын нэгжүүд<br><br>ИНҮТ | |

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн
А/146 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН "ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ"-Г ДЭЭШЛҮҮЛЭХ 2024 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах хэлтэс | Хяналт тавих нэгж |
|---|---|---|---|---|---|
| **Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр** | 1.1.Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг танилцуулах | Дүн шинжилгээ хийж, удирдлагад үр дүнг танилцуулсан байна.<br><br>Тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн байна. | 2024.03.01-2024.03.10 | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир |
| | 1.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан дутуу мэдээллүүдийг нийтэд ойлгомжтой байдлаар байршуулж, сар бүр мэдээллийг шинэчлэх, байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг видео, инфографик хэлбэрээр ЦАХИМ ХУУДСАНД тогтмол байршуулах. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг ил тод байршуулсан байна. | 2024.03.10-2024.09.01 | ЗУХЭЗХ-ийн дарга З.Туяа<br><br>ИНҮТ-ийн ХАХ-ийн дарга Р.Амарбаясгалан | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир<br><br>ИНҮТ-ийн дарга Э.Төрбаяр |
| | 1.3.Байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг цахим орчинд олон нийтэд сурталчлах, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах. | - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3-аас доошгүй удаа тухайн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах мэдээлэл гаргасан байна. | 2024.03.01 2024.09.01 | ИНҮТ-ийн ХАХ-ийн дарга Р.Амарбаясгалан | ИНҮТ-ийн ЗХАГ-ын дарга Э.Нарантунгалаг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | - Бүх нийтийг хамарсан арга хэмжээний үеэр байгууллагын үйл ажиллагаag сурталчлах 2-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>- Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграм, цахим хуудас/ зэрэгт тухай бүр мэдээлэл байршуулж, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэсэн байна. | | | |
| | 1.4.Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан бичлэг, сэтгэгдэл, пост мэдээллийг бэлтгэж, олны танил, эсхүл цахим орчинд олон дагагчтай хүмүүсээр түгээлгэх. | Олны танил 5-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байна. | 2024.03.01-2024.07.01 | ИНҮТ-ийн ХАХ-ийн дарга Р.Амарбаясгалан | ИНҮТ-ийн ЗХАГ-ын дарга Э.Нарантунгалаг |
| | 1.5.Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан подкаст бэлтгэж, нийтэд түгээх. | Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 3 подкаст бэлтгэж, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн байна. | 2024.05.01-2024.07.01 | ИНҮТ-ийн ХАХ-ийн дарга Р.Амарбаясгалан | ИНҮТ-ийн ЗХАГ-ын дарга Э.Нарантунгалаг |
| | 1.6.Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах. | -Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байна.<br>-Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байсан байна. | 2024.03.01-2024.04.30 | ААДХДБА-ны дарга С.Ерханат<br><br>ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр** | 2.1.Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах. | 2-оос доошгүй удаа сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2024.04.01-2024.05.30 | ЗУХЭЗХ-ийн дарга З.Туяа<br><br>ИНҮТ-ийн ХХ<br><br>ИНҮТ-ийн ЗХАГ-ын менежер Д.Сувдаа | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир |
| | 2.2.Байгууллагын удирдах албан тушаалтан нийт алба хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, удирдлагын зүгээс авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлэх. | - Албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br><br>-Авлигын зөрчлийн талаар мэдээлэл өгөх сувгуудыг сурталчилсан байна.<br><br>-Мэдээ, мэдээллийн мөрөөр хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, буруутай албан хаагчдад хариуцлага тооцсон байна. | 2024.03.01-2024.09.15 | ИНҮТ-ийн ХХ<br><br>ИНҮТ-ийн ЗХАГ-ын менежер Д.Сувдаа | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир |
| | 2.3.Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдаас нууц санал асуулга авч, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авах. | -Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байна.<br>- АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байна. | 2024.03.01-2024.03.15<br><br>2024.03.30-2024.05.30 | ЗУХЭЗХ-ийн дарга З.Туяа<br><br>ИНҮТ-ийн ХХ<br><br>ИНҮТ-ийн ЗХАГ-ын менежер Д.Сувдаа | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2.4.Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахыг хориглох, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах. | Эрсдэлтэй ажлын байранд ажилладаг албан хаагчдаар баталгаа гаргуулсан байна. | 2024.03.01<br>2024.03.15 | ЗУХЭЗХ-ийн дарга З.Туяа | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир |
| | | Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2024.04.01-<br>2024.04.30 | ИНҮТ-ийн ХХ<br><br>ИНҮТ-ийн ЗХАГ-ын менежер Д.Сувдаа | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир |
| | 2.5.Албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа авах нь авлигын зөрчил болох талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг тусгайлан зохион байгуулах (кейс бүхий дэвжээ, АХА бусад уралдаан тэмцээн зохион байгуулж болно.) | -2-оос доошгүй сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2024.03.01-<br>2024.04.30 | ЗУХЭЗХ-ийн дарга З.Туяа<br><br>ИНҮТ-ийн ХХ<br><br>ИНҮТ-ийн ЗХАГ-ын менежер Д.Сувдаа | ХШҮДАА-ны дарга Б.Мөнх-Очир<br><br>ИНҮТ-ийн АБЧУГ-ын дарга Н.Идэр |
| **Бодлогод оролцогчдын үнэлгээ** | 3.1.Байгууллагын удирдах албан тушаалтан иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудтай болон үнэмлэх, | -Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | 2024.05.01-<br>2024.09.01 | НААХЗА-ны дарга П.Ганболд | ААДХДБА-ны дарга С.Ерханат |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **сайжруулах чиглэлээр** | гэрчилгээ эзэмшигчтэй албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар санал, хүсэлтийг авч, зөрчлийг засаж залруулах арга хэмжээ авах. | -Гарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар санал, хүсэлтийг авч, зөрчлийг засаж залруулах арга хэмжээ авсан байна. | | | |